



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/393

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 29.1.6-гийн “л”, 30.1.6. дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын зөвлөлийн 34 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Увс аймгийн Улаангом суманд байрлах Хилийн цэргийн 0245 дугаар ангид үүсээд байгаа нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж арга хэмжээ авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар: Л.Дамдинсүрэн- аймгийн эрүүл мэндийн газрын дарга

Гишүүдэд:


Д.Бямбацогт- Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга

С.Чагнаадорж -Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга

2. Ажлын хэсгийн унааны бензин, томилолтын зардал 1200000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Г.Төмөрбаатар, нягтлан бодогч Ц.Нармандах нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР